



БАЙГАЛЬ ОРЧИН,
НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ

2013 оны 10-р сарын 29


Нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл буюу Японы хамтарсан кредит олгох механизмын талаар

Уур амьсгалын өөрчлөлтийн зохицуулах алба

Агуулга

- Зах зээлийн механизм гэж юу вэ?
- Шинэ механизм буюу Японы хамтарсан кредит олгох механизмын талаар
- Монголд ХКОМ-ыг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага ач тус

Нүүрстөрөгчийн санхүүжилт гэж юу вэ?




Нүүрстөрөгчийн зах зээл

Нүүрстөрөгчийн зах зээлийн үндэс суурийг НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (НҮБУАӨСК)-оор бий болгосон бөгөөд уг конвенцийн хүрээнд бий болсон Киотогийн протокол түүнийг даган гарсан хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах талаар үндэсний болон олон улсын хууль, дүрэм журам нь нүүрстөрөгчийн зах зээлийг бий болгодог.

Зах зээлийн механизмууд

Хүлэмжийн хийн ялгаралтын бууралтын худалдаа



Хүлэмжийн хийн ялгаралтын бууралтын худалдаа хэрхэн явагддаг вэ? Яаж нүдэнд үзэгдэхгүй гарт баригдахгүй хийг зах зээл дээр худалдаалагдах бараа, бүтээгдэхүүн болгон хувиргадаг вэ?


Хүлэмжийн хийн ялгаруулах эрхийн худалдаа



а/Хүлэмжийн хийнүүдийг тодорхойлох
б/Тэдгээр хүлэмжийн хийг хооронд нь харьцуулах үүднээс нэг хэмжигдэхүүнээр илэрхийлэх
в/Зах зээл дээр худалдаалагдах стандарт барааг бий болгох

Нүүрстөрөгчийн зах зээл, нүүрстөрөгчийн худалдаа гэж юж вэ?

1. Хүлэмжийн хийн ялгаралтын бууралтын кредитүүд болон хүлэмжийн хийн ялгаралтын эрхүүд худалдаалагддаг зах зээл юм.
2. **Зах зээлийн эрэлтийг** олон улсын, үндэсний, бүсийн болон орон нутгийн бодлого, хууль, дүрэм, журмаар бий болгож байдаг.
3. Хүлэмжийн хийн ялгаралтын бууралт болон шингээлтийг хэмжих, тайлагнах, нотлох талаар маш нарийн **техник, стандарт зохицуулалт** дээр суурилдаг.
4. Цэвэр, нүүрстөрөгч багатай хөгжлийн **хөшүүрэг** болж тогтвортой хөгжлийг дэмжих нэг механизм болдог.



Эх сурвалж: Нүүрстөрөгчийн зах зээлийн өнөөгийн байдал, цаашдын хандлага 2012

Цэвэр хөгжлийн механизм: төсөл хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлууд

Саад бэрхшээл	Өмнө хэр том саад байсан	Одоо хэр том саад болж байгаа
Хэмжээ-төсөл боловсруулалтын зардлын саад бэрхшээл	Дунд зэрэг	Өндөр
Төрөл – ашиглахад түвэгтэй аргачлалаас үүдэлтэй саад бэрхшээл	Өндөр	Өндөр
Ойжуулалтын төслийн зах зээлийн саад бэрхшээл	Өндөр	Өндөр
ЦХМ-ын зөвлөх үйлчилгээний саад бэрхшээл	Бага	Бага
Эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалтын саад бэрхшээл	Маш өндөр	Маш бага буюу бараг байхгүй
Баримтжуулах саад бэрхшээл	Дунд зэрэг/бага	Дунд зэрэг/бага
Санхүүжилтийн саад бэрхшээл	Өндөр	Өндөр
Ойлголтын саад бэрхшээл	Дунд зэрэг/өндөр	Маш бага
Эрэлтийн саад бэрхшээл	Байхгүй	Өндөр

Японы хамтарсан кредит олгох механизмын хүрээнд эдгээр хамгийн ихээхэн саад болж буй хүчин зүйлс, асуудлуудыг тодорхой хэмжээнд арилгах боломжтой.

	ЦХМ-ын бүртгэгдсэн төсөл					Буцаагдсан
	Төслийн тоо	Нэг жилд бууруулах дундаж (тн CO ₂)	2012 он хүртэл нийт бууруулах хэмжээ(тнCO ₂)	Олгогдсон ЯББ (тн CO ₂)	Шинэчлэгдсэн	
Усан цахилгаан станц	2	30,000	302,173	76,950	0	0
Салхин Парк	1	178,778	0	0	0	0
Эрчим хүчний үр ашиг	2	62037	83,328	0	0	0
Нийт	5	62,670.5	385,501	76,950	0	0


Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах хэрэгцээ шаардлага

2 °C
[IPCC]



•Конвенцийн талуудын 17-р бага хурлаас ХХ-н ялгаралтыг бууруулах үйл ажиллагааг нэмэгдүүлэх, үр ашигтай бага зардлаар бууруулах боломжыг олгох зорилгоор одоо байгаа зах зээлийн механизмууд дээр нэмэлт байдлаар шинэ арга хэрэгсэл, механизмыг бий болгон хэрэгжүүлэх талаар тохирсон

Дэлхийн нийт ХХ-н
ялгаралт
(Гига тн CO₂-той
тэнцүү/жилд)



Одоо байгаагаараа
явбал бий болох
хандлага

Олон улсын амлалт,
хүлээсэн үүргээ
биелүүлсэн үеийн
хандлага


Олон улсад хараахан тогтоогүй
боловч үндэсний хэмжээнд тогтоосон
хамгийн их бууруулах үүрэг хүлээсэн
үеийн санал, бодлогын үеийн
ялгаралтын хандлага

Температурын өөрчлөлтийг 2
градусаас хэтрүүлэхгүй байлгахад
шаардагдах ялгаралтын хандлага
2100 он гэхэд температурын
өөрчлөлтийг 1,5 градусаас
хэтрүүлэхгүй байлгах ялгаралтын
түвшин/хандлага


Эх сурвалж: Analytics/PIK, 2012

Японы санаачлага: Хамтарсан кредит олгох механизм (ХКОМ)

- ХХ-н ялгаралтыг бууруулж, ялгаралтын бууралтын кредитийг бий болгох хоёр талын буюу хамтарсан механизм юм.
- ЦХМ-ыг бодвол илүү хялбар, уян хатан, төсөл боловсруулалтын зардал багатай байна
- ХХ-н ялгаралтыг бодитоор, хэмжиж тайлагнаж нотлож болохуйц байдлаар бууруулж төсөл хэрэгжиж буй орны нүүрстөрөгч багатай тогтвортой хөгжилд хүрэхэд хувь нэмэр оруулах



Монголд ХКОМ-ыг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага ач тус



Эх сурвалж: Ази Номхон далайн бүсийн хүний хөгжлийн тайлан, 2012

Манай орны хувьд нэгж эрчим хүч үйлдвэрлэхэд ялгаруулж байгаа нүүрстөрөгчийн хийн хэмжээ бүс нутгийн бусад орнуудтай харьцуулахад хамгийн өндөр байна.


Монголд ХКОМ-ыг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага ач тус (2)

Country	Energy Produced	Net Imports	Total Primary Energy Supply (Mtoe)	Share in Energy Consumption (%)	
				Renewables	Fossils
Bangladesh	24.8	5.0	29.6	30.2	69.8
Cambodia	3.7	1.6	5.2	70.8	27.8
China	2,084.9	274.9	2,257.1	11.9	87.4
India	502.5	182.0	675.8	26.1	73.0
Indonesia*	351.8	-153.6	202.0	34.6	65.6
Iran, Islamic Republic of	349.8	-132.1	216.2	0.5	99.7
Korea, Democratic People's Republic of	20.3	-1.0	19.3	11.0	89.0
Malaysia	89.7	-21.7	66.8	5.3	94.7
Mongolia	7.7	-4.2	3.2	3.2	96.4
Myanmar	22.4	-7.2	15.1	72.3	27.7
Nepal	8.8	1.2	10.0	88.5	11.1
Pakistan	64.9	19.8	85.5	37.4	61.8
Philippines	23.5	16.3	38.8	43.0	57.0
Sri Lanka	5.1	4.3	9.3	54.7	45.3
Thailand	61.7	47.4	103.3	20.5	79.4
Viet Nam	76.6	-13.8	64.1	43.3	56.2
World	12,292.0	..	12,150.0	13.1	80.7

Монгол улсад эрчим хүчний үйлдвэрлэл буюу хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээ дэлхийн дундаж болон бүс нутгийн бусад орнуудтай харьцуулахад (Ираныг эс тооцвол) хамгийн бага хэмжээтэй байна.

Эх сурвалж: Ази Номхон далайн бүсийн хүний хөгжлийн тайлан, 2012

Монголд ХКОМ-ыг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага ач тус (3)



Манай орны хувьд нэгж үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд царцуулж буй эрчим хүчний хэрэглээ Ази-номхон далайн бусад улс орнуудтай харьцуулахад хэд дахин өндөр байна.

Эх сурвалж: Ази Номхон далайн бүсийн хүний хөгжлийн тайлан, 2012

Монголд ХКОМ-ыг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага ач тус (4)

Алдагдлыг бууруулан, үр ашигийг нэмэгдүүлэх

Эрчим хүчний алдагдлыг бууруулан үр ашигийг нэмэгдүүлснээр хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах боломж их байна.

Эрчим хүчний хэрэглээ

Монголд халаалтын улирал нь 9 сар үргэлжилдэг бөгөөд барилга, байшин, гэрүүд нь дулааны өндөр алдагдалтай байна.




Дулаалга муутай гэр
Дулаалга сайтай гэр
Дулаалга муутай байшин
Дулаалга сайтай байшин
1997 оноос хойш баригдсан баригдсан орон сууц
1997 оноос хойш баригдсан угсармал орон сууц

Эх сурвалж: НҮБХХ-ийн Барилгын эрчим хүч хэмнэлтийн төсөл

Эрчим хүчний үйлдвэрлэл

Эрчим хүчний хуваарьлалт (2011)




ДЦС-уудын үйлдвэрлэсэн нийт цахилгааны 30 гаруй хувийг дотоод хэрэглээ, түгээлтийн алдагдал эзэлж байна. Дотоод хэрэглээг бууруулах, алдагдлыг багасгаж үр ашигийг нэмэгдүүлэх замаар хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах боломж ихээхэн байна.

Эх сурвалж: Эрчим хүчний яам

Монголд ХКОМ-ыг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага ач тус (5)

Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх




Source: Ministry of Energy, Mongolia

Монголд салхиный эрчим хүчний арвин их нөөц байгаа бөгөөд салхин эрчим хүчний томоохон үйлдвэрлэгч болох боломжтой юм;
Сайнаас маш сайн гэж тооцогдох салхиный эрчим хүчний нөөц **1,100 ГВт байна.**

Монголд сэргээгдэх эрчим хүчний (нар, салхи ...) арвин их нөөц байгаа бөгөөд одоогоор төдийлөн ашиглагдаагүй байна.

Нарны эрчим хүчний жилийн дундаж хэмжээ нь 1,400 кВт цаг/м²/ жилд
нарны эрчим нь 4.3-4.7 кВт цаг/м² өдөрт.



Source: U.S Department of Energy

Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр

Стратеги зорилт

1. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас гарч байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог бүрдүүлэх;
2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бүрдүүлж, байгаль орчны тэнцвэрт байдлыг ханган, эдийн засаг, нийгмийн эмзэг байдал, эрсдэлийг үе шаттайгаар бууруулах;
3. Байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх, үйлдвэрлэл, хэрэглээний үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх замаар хүлэмжийн хийн ялгаралтыг үе шаттайгаар бууруулж, карбон багатай эдийн засагт шилжих эхлэлийг тавих /үүнд “карбон багатай эдийн засаг” гэж хүлэмжийн хийн ялгаралт багатай үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх явдал давамгайлсан эдийн засгийг хэлнэ/;
4. Уур амьсгалын ажиглалтын сүлжээг өргөтгөх, технологийн шинэчлэл хийх, судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажлыг өргөжүүлэх, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх;
5. Олон нийтийг уур амьсгалын өөрчлөлтийн тухай мэдээллийг хүн амд өгөх, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагаа, арга хэмжээнд идэвхтэй оролцоход нь дэмжлэг үзүүлэх.


1-р үе шат (2011-2016)

- Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үндэсний чадавхийг бэхжүүлэх.
- Эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог бүрдүүлэх.
- Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.

2 – үе шат (2017-2021)

- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох боломжит арга хэмжээг хэрэгжүүлэх
- Хүлэмжийн хийн ялгаралтын өсөлтийг сааруулах үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх.

Монголд ХКОМ-ыг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага ач тус (4)




ХКОМ нь дараахь бодлого, хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ:

1. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийн стратегийн 3-р зорилт
2. Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр
3. Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ
4. Монгол улсаас НҮБ/УАӨСК-ийн Копенгагены тохиролцооны хүрээнд өргөн мэдүүлсэн хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах зохистой арга хэмжээний жагсаалтад орсон үйл ажиллагаанууд
5. г.м

Олон улсын нүүрстөрөгчийн санхүүжилтийн механизмтай холбосноор:

1. Олон улсын стандартад нийцсэн хянах, тайлагнах тогтолцоог нэвтрүүлэх,
2. Төслийн санхүүжилтийг шийдвэрлэснээр урт хугацаанд тогтвортой ажиллах боломж бүрдэж, ирээдүйд орж ирэх урсгал санхүүжилтийн эх үүсвэртэй болох боломжтой.

ХКОМ-ыг хэрэгжүүлэх үндсэн үе шат



- 1) **Засгийн газар хоорондын түншлэлийн ерөнхий гэрээг байгуулах**
- 2) Хоёр орны төр, засгийн газар хувийн хэвшлийн оролцоотой хамтарсан хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах төсөл хэрэгжүүлэх
- 3) Тухайн хүлэмжийн хийн ялгаралтын бууралтад кредит тооцуулж Япон улсын ХХ-н ялгаралтыг бууруулах зорилтод тооцуулахаар шилжүүлэн өгөх эсвэл олон улсад Монгол улсын нэр дээр тооцуулах

Японы талаар зарим баримтаас

- Япон нь Дэлхийд CO₂-ийн ялгаруулалтаараа 5-д орж байна.
- Япон олон улсын хэмжээнд 2020 он гэхэд хүлэмжийн хийн ялгаралтаа 1990 оныхоо түвшинтэй харьцуулахад 25 % **-иар бууруулна гэдгээ зарласан.** (Уур амьсгалын өөрчлөлтийг эсрэг хариу арга хэмжээний тухай үндсэн хуулийн төсөлд тусгагдсан)
- Япон энэхүү зорилгоо биелүүлэхэд зөвхөн дотооддоо арга хэмжээ авах нь хангалтгүй байна гэдэг нь тодорхой юм. Тиймээс Япон бусад улс орнуудаас хүлэмжийн хийн ялгаралтын бууралтын кредит худалдан авах замаар энэхүү амлалтаа биелүүлнэ гэж хүлээгдэж байна.
- Япон Киотогийн протоколын 2-р үүргийн хугацаанд оролцохгүй гэдгээ мэдэгдсэн. Тиймээс 2012 оноос хойш Япон ЦХМ-ын төслийн кредитийг ХХ-н ялгаралтаа бууруулах зорилтоо биелүүлэхэд голчлон ашиглахгүй харин ХКОМ-ын кредитийг ашиглана гэж төлөвлөж байна.
- Япон ХХ-н ялгаралтаа бууруулахаар тавьсан 25 хувийн зорилтынхоо зөвхөн 10 хувийг ХКОМ-ын кредитийг ашиглан биелүүлнэ гэж үзэхэд жилд 100 сая тонн CO₂-той тэнцүү ХКОМ-ын кредит шаардлагатай гэсэн тооцоо байна.

Дүгнэлт, цаашдын алхам

Дүгнэлт:

- ХКОМ нь Монгол улсын хувьд уур амьсгалын өөрчлөлт болон холбогдох бусад бодлого , хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ногоон хөгжилд хүрэхэд дэмжлэг үзүүлэх нэг чухал механизм болох боломжтой
- ХКОМ-ын тусламжтай Монгол улс хүлэмжийн хий бага ялгаруулдаг өндөр технологийг өртөг багатайгаар өөрийн орон нэвтрүүлж нутагшуулах боломжтой

Цаашдын алхам:

- ХКОМ-ын үр ашигийг хүртэхийн тулд түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүй, зохицуулалтын орчинг нэн яаралтай бий болгох шаардлагатай байна.
- ХКОМ-ыг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтыг бий болгож чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх
- Боломжит төслийн саналуудыг гаргаж ирэх, хамтарсан төсөл хөтөлбөр туршилтын байдлаар буюу загвар болгон хэрэгжүүлэх
- Монгол болон Японы хувийн хэвшлийн байгууллагуудын түншлэлийг нэмэгдүүлэх

Анхаарал тавьсанд
баярлалаа!

www.mne.gov.mn

www.climatechange.gov.mn

www.cdm-mongolia.com